

**ШУУРХАЙ ХЯНАЛТЫН ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
ЦОГТСАЙХАН ОВОГТОЙ ХАТАНБОЛДЫН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин /Эхний хагас жил/	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5	6	7	
Зорилт 1. "УЛСЫН ХИЛЭЭР ХУУЛЬ БУСААР БАРАА ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ НЭВТРҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ"								
1.	Теле хяналтын нэгдсэн систем, камерын хэвийн, найдвартай, аюулгүй байдлыг ханган ажилласан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	ГЕГ-т бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа нийт 164 гаалийн хяналтын бүс байгаагаас өнөөдрийн байдлаар нийт 145 гаалийн хяналтын бүсийн тухайн аж, ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтаар суурилуулсан 1520 хяналтын камерыг ГЕГ-ын телехяналтын нэгдсэн системд холбож, хяналтын нэгдсэн төвөөс хяналт тавих, холбогдох нэгжүүдийг мэдээллээр хангах нөхцөл бололцоо бүрдсэн.	Харьяа гаалийн газар, хороод, гаалийн хяналтын бүсүүдэд ашиглагдаж буй дэд систем, хяналтын камер бусад тоног төхөөрөмжийн тоо бүртгэл, графикт үзлэг үйлчилгээ, ашиглалтад хяналт тавих, хэвийн тасралтгүй ажиллагааг хангах чиглэлээр ажил зохион байгуулсан байна.	<i>ТХНС, дагалдах тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллааг хангах чиглэлээр:</i> • Шуурхай хяналтын төвд харьяа гаалийн газар хороодоос ирүүлсэн гэмтэлтэй, засварлуулах шаардлагатай телекамер болон бусад дагалдах тоног төхөөрөмжийн бүртгэлийг тухай бүрт нь хөтлөн, шаардлагатай засвар үйлчилгээг шийдвэрлүүлэх ажлыг удирдлагаар ханган ажилласан. Энэ ажлын хүрээнд 2019 онд "Ай Ти Зон" ХХК-тай байгуулсан "Гаалийн хяналт шалгалтын телехяналтын нэгдсэн системийн иж бүрдэл бүхий тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах" 112/2019, IZI-243-19-321 тоот гэрээний дагуу харьяа гаалийн газар хороодод суурилуулсан тоног төхөөрөмжүүдээс 2024.01.02-ны өдрийн байдлаар эвдрэл, гэмтэлтэй, засварлуулах шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн судалгааг гарган, баталгаат засварын хугацаанд засварлуулахаар жагсаалтыг 2024.01.16-ны өдрийн 01-5/222, 2024.05.30-ны өдрийн 01-1/2133 тоот албан бичгээр "Ай Ти Зон" ХХК-д хүргүүлж засварлуулсан. 2024.12.3-ны өдрийн байдлаар 8 газар хорооны 13 тог баригч, 8 хөргөлтийн системийг бүрэн засварлаж суурилуулан ажиллагаанд оруулсан тухай актыг үйлдэж хүлээлцэн авсан. Сангийн яам болон Тотал технологи ХХК-ийн байгуулсан №127/ТТ-24/07-015 дугаартай "Хилийн	2024.01.02-2024.11.30	100%	

			<p>шинэчлэлтийг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулсан байна.</p>	<p>боомтуудад телехяналтын тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ"-ний дагуу ЗҮГГ-ын ачаа тээврийн цогцолбор, ГСГГ-ын боомтод суурилуулагдсан телекамерыг ТХНС-д холбон, хяналт тавих нөхцөл боломжийг хангасан.</p> <p>ЗУГ-с ирүүлсэн Алтанбулаг чөлөөт бүсийг телехяналтын нэгдсэн системд холбох ажлын хүрээнд тус бүсэд 11 дүгээр сард шилэн кабел татагдсан ба телекамеруудын байршлыг тогтоон, гаалийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох ажил хийгдэж байна.</p> <p>Багахангай, Сүхбаатар, Сайншанд боомтуудад үйл ажиллагаа шинээр эхлэх гэж буй аж ахуйн нэгжүүдтэй уулзалт хийж телехяналтын системийн талаар зөвлөгөө, чиглэл өгсөн.</p> <p>ХБГ-аас ирүүлсэн дотоод зурвасын дагуу шинээр ГХБ-ээр зарлуулахаар хүсэлт өгсөн 19 аж ахуйн нэгжүүд нь нийт журмын шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавин, шаардлагыг хангуулсан.</p> <p>Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/248 тушаалын хавсралтаар батлагдсан "Хяналтын нэгдсэн төвийн үйл ажиллагааны заавар"-ын 5.2-5.7 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг хангах зорилгоор харьяа гаалийн газар хороодод телехяналтын дэд төвийн системийн хэвийн найдвартай ажиллагаа, арчилгаа үйлчилгээ, ашиглалтын чиглэлээр дотооддоо зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах чиглэлийг 2024.02.07-ны өдрийн 01-5/495, 2024.03.25-ны өдрийн 01-2.2/1129 тоот албан бичгүүдээр тус тус хүргүүлж, телехяналтын дэд систем, дагалдах тоног төхөөрөмжийн ашиглалтын мэдээг сар бүр байршуулж хэвшүүлснээр нэмэлтээр бичлэг хадгалах камер, дэлгэц, свич зэрэг шаардлагатай тоног төхөөрөмжийн саналыг холбогдох нэгжид хүргүүлж, шийдвэрлүүлсэн.</p>		
--	--	--	--	--	--	--

				<p>Тайлант хугацаанд нэгжийн дарга Ц. Хатанболд, ГУАБ Д. Ганцолмон, ГУБ Ш.Батболд, Б.Болдбаяр, Б.Дөлгөөн, Н.Дөлгөөн нар ЧХОУНБГГ, УХШИГГ, СЭГГ,УБГГ, ЗҮГГ, БигГ, ШХГГ, ГСГГ, ХоГГ, Боршоо, Арцсуурь, Ханги боомтууд болон БЦТ-д ашиглаж буй телехяналтын дэд систем, ухаалаг гарц, рентген тоног төхөөрөмжийн холболт тохиргоо хийх, тэдгээрийн хэвийн ажиллагааг хангуулах зорилгоор 25 удаагийн томилолтоор ажилласан.</p> <p>АТГ-с ирүүлсэн мөрдөгчийн мэдэгдлийн дагуу ЧХОУНБуудал дахь гаалийн газарт гэмт хэрэг гарсан шалтгаан нөхцлийг арилгах зорилгоор Карго терминалын давхар хоорондын шатны хонгилд камер суурилуулах мэдэгдэл ирсний дагуу тус байршилд 1 ширхэг хөдөлгөөнгүй камер суурилуулж тайланг ХБГ-т хүргүүлсэн ба Авилгатай тэмцэх газрын мөрдөгчийн мэдэгдэл болон ГЕГ-ын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодоос ирүүлсэн тайлангийн дагуу газар хороодод хяналтын камер суурилуулах үнийн судалгааг гарган СХОГ-т шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн.</p> <p>Телехяналтын камер, дагалдах тоног төхөөрөмжийн судалгааны чиглэлээр:</p> <p>“Хилийн үр ашгийг нэмэгдүүлэх тогтвортой худалдаа төсөл”-ийн хүрээнд хэрэгжих Хавирга, Цагааннуур, Булган боомтуудын өргөтгөл шинэчлэлийн бүтээн байгуулалтад шаардагдах телекамер болон дагалдах тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, байршил, тоо ширхэгийн судалгааг хийж хүргүүлсэн.</p> <p>Дорноговь аймгийн ЗҮГГ-ын ачаа тээврийн цогцолбор, ГСГГ-ын хяналтын бүсүүдэд суурилуулах телехяналтын камер болон бусад дагалдах тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, байршлыг тодорхойлж Сангийн яаманд хүргүүлсэн. Тендерт шалгарсан оролцогчтой Сангийн яамны байгуулсан СЯ/20240102033 дугаартай “Хилийн боомтуудад телехяналтын тоног төхөөрөмж</p>		
--	--	--	--	--	--	--

				<p>нийлүүлэх" гэрээний дагуу Замын-Үүд боомт болон Гашуунсухайт боомтод 217 ширхэг телехяналтын камер, 16 дугаар таних камер, сервер хард диск-34 холбуулж хүлээн авсан.</p> <p>ГЕГ-ын дэргэдэх Бүрдүүлэлтийн цахим төвд суурилуулах телекамерын байршил, тоо ширхэг болон дагалдах тоног төхөөрөмжийн техник үзүүлэлтийн судалгааг гарган үнэлгээний хороонд хүргүүлсэн. Тус тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй 2024 оны 11 сарын 28 өдрийн тоот телехяналтын тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах гэрээ байгуулж, гэрээний дагуу 52 ширхэг телехяналтын камер, дагалдах тоног төхөөрөмж /сервер-2, хард диск- 8, лиценз-62/нийлүүлж угсралт, суурилуулалт, холболтын ажил бүрэн хийгдэж дууссан.</p> <p>Газар, хороодод суурилуулсан телехяналтын дэд системийн бичлэг хадгалах хугацаанд судалгаа хийж, хугацааг уртасгах зорилгоор нэмэлт хард зайлшгүй шаардлагатай байгаа СХОГ-р шийдвэрлүүлж ЧХОУНБГГ-т 12ш, ЗҮГГ-т 12ш, УБГГ-т 6ш, СЭГГ-т 2ш хард диск тус тус суурилуулсан.</p> <p>Царай таних 2 сервер, ЗҮГГ-ын ачаа тээврийн цогцолборт суурилуулсан том оврын тээврийн хэрэгслийг шалгах "ИСБА" рентген тоног төхөөрөмж-1, УХШИГГ-н бичиг захидал болон ачааны рентген тоног төхөөрөмж-2, Увс аймаг дахь гаалийн газрын Боршоо боомтын импорт талын зорчигчийн болон ачааны рентген- 2, Ховд ГГ-т суурилуулсан ачаатай тээврийн хэрэгсэл шалгах рентген төхөөрөмжид-2-ийг ТХНС-тэй холбож, хяналт тавин ажиллаж байна.</p> <p>ГЕГ болон Мэйжүрмэнт ХХК-тай байгуулсан 2024 оны ГЕГ 54/24 тоот Ханги дахь гаалийн газрын зорчигч болон ачаа тээврийн хяналтын бүсэд Гаалийн хяналт, шалгалтын "Ухаалаг гарц" системийн иж бүрдэл бүхий тоног төхөөрөмж нийлүүлэх, угсрах, суурилуулах гэрээнд нэмэлт,</p>		
--	--	--	--	---	--	--

					өөрчлөлт оруулах тухай гэрээний дагуу угсарч суурилуулсан ухаалаг гарц системийн иж бүрдэл бүхий тоног төхөөрөмжийг бүрэн хүлээлцэн авч, үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд бэлтгэл ажлуудыг хангуулахаар тохиролцсон.		
2.	Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн чиглэлээр ашиглагдах бүх төрлийн мэдээллийг төрөлжүүлэн цуглуулж, сан үүсгэх, дүн шинжилгээ хийсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Уул уурхайн ашигт малтмал экспортод Замын-Үүд, Гашуунсухайт, Шивээхүрэн, Булган, Бичигт, Ханги боомтуудад LPR буюу авто тээврийн хэрэгслийн улсын дугаар таних нийт 38ш камер суурилуулан, гаалийн телехяналтын нэгдсэн системд холбон тээврийн хэрэгслийн санг үүсгэн, цаашлаад дүн шинжилгээ хийх, зөвлөмж илгээн ажиллах, "Ухаалаг гарц"-ын системтэй холбох нөхцөл бололцоог ханган ажилласан.	- Гаалийн хяналт бүрдүүлэлттэй холбоотой мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ГЕГ-ын удирдлага болон холбогдох чиг үүргийн нэгжийг мэдээллээр хангаж ажилласан байна. - Улсын хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн орсон гарсан бүртгэлийн сан, эрсдэлтэй зорчигчийн царай таних сан, зөрчилд холбогдсон барааны санд тус тус дүн шинжилгээ хийж, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавин, зөвлөмж илгээсэн байна.	Тайлант хугацаанд гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, ухаалаг гарцын систем, рентген тоног төхөөрөмжүүдийн гаалийн хяналт, бүрдүүлэлтийн чиглэлээр ашиглагдах бүх төрлийн мэдээллийг төрөлжүүлэн цуглуулж, · Улсын хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн орсон гарсан бүртгэлийн сан болон манифестийн санд хийсэн судалгаа /I болон II-р хагас жилд/Ухаалаг гарцын тээврийн санд хийсэн судалгаа /I, II, III улирлаар/ · Эрсдэлтэй зорчигчийн царай таних санд хийсэн судалгаа /Бүтэн жилээр/ · Зөрчилд холбогдсон барааны санд хийсэн судалгаа /I болон II-р хагас жилд/ · ЗҮГГ түүвэр ачааны судалгаа /8-р сар/ · ЗҮ боомтоор импортолсон хүнсний ногоо, жимсний судалгаа /6, 9-р сар/ · ЗҮ боомтоос УБГГ-ын гаалийн хяналтын бүсэд илгээгдэж буй ачааны судалгаа /11-р сар/ · Шалгуурын судалгаа /I болон II-р хагас жилд/ · Зөвлөмжийн судалгаа /I болон бүтэн жилээр/ гэх нийт 15 судалгааг хийн, Tableau дата платформыг ашиглан өгөгдөлд дүн шинжилгээ хийн 112 зөвлөмж хүргүүлэн, ГЕГ-ын удирдлага, холбогдох нэгжүүдийг мэдээ мэдээллээр цаг тухай бүрт нь ханган ажилласан байна. ЗГ-ын иргэд олон нийттэй харилцах "11-11" төв болон Гаалийн лавлах "1800-1281" тусгай дугаарт гаалийн хяналт бүрдүүлэлтийн үе шатанд гаргасан гомдол, санал, хүсэлтийг бүртгэлжүүлэн, холбогдох нэгж рүү 289 удаа хүргүүлж мөн шийдвэрлэлтийн	2024.01.02-2024.11.30	100%

					<p>мэдээллийг ГЕГ-ын дарга болон ЗТГ, ЗУГ-ын удирдлагад 7 хоног бүр танилцуулан ажилласан.</p> <p>2 улсын засгийн газар хоорондын хэлэлцээрээр батлагдсан амралтын өдөрт Шивээхүрэн боомтоор CAIS системд бүртгэлгүй, гаалийн хяналт шалгалтад хамрагдахгүйгээр улсын хилээр нэвтэрсэн 2 тээврийн хэрэгслийн үйлдлийг телехяналтын камераар илрүүлж, Зөрчилтэй тэмцэх газарт мэдээллийг хүргүүлсэн.</p> <p>ЗҮ боомтоос УБГГ-ын харьяа хяналтын бүсэд илгээгдэж буй ачаа тээврийн судалгааг хийж, цаашид Замын-Үүд боомтын ачааллыг бууруулах, гаалийн хяналт шалгалтыг сайжруулах чиглэлээр судалгаанд үндэслэн, саналыг боловсруулж дэд даргад танилцуулсан.</p>		
3.	Мэдээлэлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан онилгоо хийн, зөвлөмж илгээсэн байдал	Хэрэгжилт, хувиар	<p>Таблю дата аналитик дээр платформ хөгжүүлж буй шалгуураар өндөр эрсдэлтэй гэж онилогдсон мэдүүлэгт телекамерын системийг ашиглан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эрсдэл тооцон, 34 мэдүүлэгт зөвлөмж илгээснээс гаальд мэдүүлсэн барааны нэр төрөл, тоо хэмжээ зөрүүтэй, бараа мэдүүлэх журам зөрчсөн 21 зөрчил илрүүлж, нөхөн</p>	<p>- Мэдээлэлд дүн шинжилгээ хийн, шалгуур үзүүлэлтээр эрсдэл тооцон, илгээсэн зөвлөмж, онилгооны үр дүнд илрүүлсэн зөрчилд нөхөн төлүүлсэн татварын болон торгуулийн дүн өмнөх оны мөн үеэс 5-аас дээш хувиар өссөн байна.</p> <p>- Оновчгүй зөвлөмжийн нийт онилгоонд эзлэх хувийг өмнөх оны мөн үеэс</p>	<p>Шуурхай хяналтын төв нь батлагдсан шалгуурт үндэслэн CAIS-д мэдүүлсэн бараа тээврийн хэрэгслийн өгөгдлийг Таблю дата аналитик платформ ашиглан, бодит цагаар боловсруулан сонгогдсон эрсдэлтэй гаалийн мэдүүлэгт Телехяналтын нэгдсэн систем болон рентген тоног төхөөрөмж, ухаалаг гарц, дугаар таних системд хүлээн авсан мэдээлэлд давхар дүн шинжилгээ хийн, эрсдэл тооцож CAIS-ийн Онилгооны програмаар тайлант хугацаанд 112 зөвлөмжийг гаалийн хяналт шалгалт, бүрдүүлэлтийн бүх үе шатанд илгээсэн байна. Үүнээс 87 буюу 77.68%-д нь татвараас зайлсхийсэн болон зайлсхийхийг завдсан, эрх бүхий байгууллагын тусгай зөвшөөрлөөр улсын хил нэвтрүүлэх шаардлагатай хориглосон хязгаарласан барааг хууль бусаар хил нэвтрүүлэхийг завдсан зөрчлүүдийг тус тус илрүүлсэн байна.</p> <p>Зөвлөмжийн дагуу илрүүлсэн 87 зөрчилд Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 11.21 дүгээр зүйлийн 1.1, 1.2 заалтын дагуу арга хэмжээ авагдаж, 482.6 сая.төгрөгийн татварыг нөхөн төлүүлж, 249.38</p>	2024.01.02-2024.11.30	100%

			<p>төлүүлсэн татварын дүн: 212,059,199.09 төг, торгуулийн дүн: 108,029,599.5 төг төлүүлсэн бөгөөд өмнөх онтой харьцуулахад 118.15 хувиар өссөн үзүүлэлттэй ажилласан.</p>	<p>бууруулсан байна.</p>	<p>сая.төгрөгийн торгууль ногдуулан төлүүлсэн нь өмнөх оноос нөхөн төлүүлсэн татварын дүнгээс 6.13% хувиар, торгуулын дүнгээс 7.8% хувиар тус тус өсч, төлөвлөгөөг 100% хангаж ажилласан байна.</p> <p>Оновчгүй зөвлөмжийн нийт онилгоонд эзлэх хувийг өмнөх оны мөн үеэс эрсдэлийн шалгуур үзүүлэлт тус бүрээр харгалзах хувиар бууруулсан байдлыг зөвлөмжийн судалгаанаас харж болно. Шалгуур тус бүрээр үзвэл Барааны жин, Бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацаа, Эрсдэлтэй барааны шалгуурт илгээсэн зөвлөмж 100% оновчтой, эрсдэлтэй мэдүүлэг шалгуурт илгээсэн зөвлөмж давхардсан тоогоор орчим хувийн оновчтой байсан байна. Бүх шалгуурын хувьд авч үзэхэд нийт онилгоонд эзлэх оновчгүй зөвлөмжийн хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.18%-иар бууруулж, төлөвлөгөөнийг гүйцэтгэлийг бүрэн хангаж ажилласан байна.</p>		
4.	<p>Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн бүх үе шатанд тавьсан хяналт, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлсэн байдал, аюулгүй байдлыг хангахад хамтран ажилласан байдал</p>	<p>Хэрэгжилт, гүйцэтгэлээр</p>	<p>1. Тайлант хугацаанд ГУАБ, ГУБ нар хуваарилагдсан газар хороод, гаалийн хяналтын бүсэд телекамерын нэгдсэн систем болон таблью дата аналитик платформ ашиглан хяналт тавьж, өндөр эрсдэлтэйд тооцсон гаалийн мэдүүлэгт дүн шинжилгээ хийн, CAIS гаалийн автоматжуулсан системээр нийт 34</p>	<p>- Теле хяналтын нэгдсэн систем, ухаалаг гарц, рентген төхөөрөмжийг ашиглан гаалийн хяналт, бүрдүүлэлтийн бүх үе шатанд эрсдэл тооцож, илрүүлсэн зөрчлийн тоо өмнөх оны мөн үеэс 5-аас дээш хувиар өссөн байна.</p> <p>- Төрийн бусад байгууллагуудтай хамтран хууль сахиулах үйл</p>	<p>Шуурхай хяналтын төв нь батлагдсан шалгуурт үндэслэн CAIS-д мэдүүлсэн бараа тээврийн хэрэгслийн өгөгдлийг Таблью дата аналитик платформ ашиглан, бодит цагаар боловсруулан сонгогдсон эрсдэлтэй гаалийн мэдүүлэгт Телехяналтын нэгдсэн систем болон рентген тоног төхөөрөмж, ухаалаг гарц, дугаар таних системд хүлээн авсан мэдээлэлд давхар дүн шинжилгээ хийн, эрсдэл тооцож 2023 оны ГЕГ-ын даргын А/248 тоот тушаалын хавсралтаар батлагдсан Хяналтын нэгдсэн төвийн үйл ажиллагааны зааврын дагуу CAIS-ийн онилгооны програмаар тайлант хугацаанд 112 зөвлөмжийг гаалийн хяналт шалгалт, бүрдүүлэлтийн бүх үе шатанд илгээсэн байна. Зөвлөмж илгээсэн үе шатны хувьд 2023 онд зөвхөн бүрдүүлэлтийн хяналтын үе шатанд ХШГУБ руу илгээн ажилласан бол 2024 онд бүрдүүлэлтийн бүх үе шатанд хяналт тавин, эрсдэл тооцож, зөвлөмж илгээн ажилласан. Тайлант хугацаанд бичиг баримтын шалгалтын үед 1 зөвлөмж илгээн</p>	<p>2024.01.02-2024.11.30</p>	<p>100%</p>

мэдүүлгийн үе шатанд зөвлөмж илгээн, гаальд мэдүүлсэн барааны нэр төрөл, тоо хэмжээ зөрүүтэй 21 зөрчил илрүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 50%-иар, илгээсэн зөвлөмжид эзлэх хувь 7.9%-иар тус тус өссөн үзүүлэлттэй ажилласан.

2. 2023 оны 2 дугаар улиралд Цагдаа, Тагнуулын байгууллагатай хууль сахиулах үйл ажиллагаанд хамтран ажиллах ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд 2023 оны 06 дугаар сард хамтарсан ажиллагааг хийж гүйцэтгэсэн.

2023.04.11-ний өдөр ДоГГ-ын Хавирга боомтод гал түймэр гарсан. Тухайн цаг мөчид ТХНС-д холбогдсон телехяналтын камерын

ажиллагаанд теле хяналтын нэгдсэн системийг үр бүтээлтэй ашигласан байдал өмнөх оны мөн үеэс 3-аас дээш хувиар өссөн байна.

- Теле камерыг ашиглан гаалийн байгууллагын барилга байгууламж, албан хаагчдын аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.

хяналтыг хэрэгжүүлж, үнэлгээг хянуулан 10.7 сая.төг-ний татвар нэмж төлүүлэн, биет шалгалтын үед 108 зөвлөмж илгээж 84-д нь зөрчил илрүүлэн, "Гааль зөвшөөрөв" төлөвт орсоны дараа 3 зөвлөмжийг Зөрчил хариуцсан ГУБ руу илгээж дахин шалгалын хяналтыг хэрэгжүүлж, 2 зөрчил илрүүлэн холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авагдаж, үр дүн гарсан байна.

Бүрдүүлэлтийн үе шат	2023*		2024*		Өсөлт бууралт
	Илгээсэн зөвлөмж тоо	Зөрчил илрүүлэлт	Илгээсэн зөвлөмж тоо	Зөрчил илрүүлэлт	
ББ ГУБ (Бичиг баримтын шалгалт)		-	1	100%	100%
Зөрчил (Гааль зөвшөөрөв)		-	2	100%	100%
Зөрчил - ГЕГ (Гааль зөвшөөрөв)		-	1	50%	50%
ХШ ГУБ (Биет шалгалт)		72.50%	108	77.70%	9.20%
Нийт	80	72.50%	112	77.68%	5.18%

Тайлант хугацаанд илрүүлсэн зөрчлийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 50%-иар, илгээсэн нийт зөвлөмжид эзлэх зөрчил илрүүлэлтийн хувь нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.18%-иар тус тус өсч, гүйцэтгэлийг бүрэн хангаж ажилласан.

Тайлант хугацаанд АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэсээс ирүүлсэн 06/10415, 06/11363, ЦЕГ-ын Экологийн цагдаагийн албанаас ирүүлсэн 14-5/840, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхээс ирүүлсэн 01/5152 тоот албан бичгүүдийн дагуу хууль сахиулах ажиллагааны хүрээнд нотлох баримт бэхжүүлэх зорилгоор Телехяналтын нэгдсэн системийн өгөгдлийн сангаас бичлэг хуулбарлан, улсын хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн холбогдох мэдээллийг 4 удаагийн албан бичгээр хариу хүргүүлж хамтарч ажилласан. Мөн ЗТГ-аар дамжуулан бусад хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу бичлэгийг баримтжуулан хуулбарлаж, 12 удаа хүргүүлж, хууль сахиулах ажиллагаанд туслан дэмжиж ажилласан нь өмнөх оны мөн үеэс 40%-иар өссөн үзүүлэлттэй байна.

			<p>тусламжтайгаар хилийн боомтын барилга байгууламж, албан хаагчдын орон байрт түймэр ойртож буй талаар ГЕГ-ын удирдлагуудад шуурхай мэдээллэж ажилласан.</p>		<p>Телекамерийн хяналтаар Шивээхүрэн боомтоор 2 тээврийн хэрэгсэл /LC200 маркын 4200ӨМА, Хьюндай маркын 1436ХЦА/ CAIS системд бүртгэлгүй, гаалийн хяналт шалгалтад хамрагдахгүйгээр 2024 оны 03 дугаар сарын 10-ны буюу амралтын өдрийн 11 цаг 43 минутад гарч, 2024 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 12 цаг 05 минутад буцаж орж ирсэн. Уг үйлдэл нь Хилийн тухай хуулийн 17.2, ГЕГ-ын даргын 2019 оны А/275-р тушаалаар баталсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ын 3.2 дэх заалтуудыг зөрчсөн байх тул шалгуулахаар ЗТГ-т шилжүүлсэн. 2024 оны 6 дугаар сард орсон их борооны үеэр гаалийн байгууллагын барилга байгууламж, албан хаагчдын аюулгүй байдлыг үер усны аюулаас сэргийлэх үүднээс болзошгүй боомт, хяналтын бүсүүдэд онцгойлон хяналт тавин ажилласан.</p> <p>ЗҮ боомтод суурилуулсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг авто тээврийн хэрэгслээр мөргөж гэмтээсэн 3 удаагийн үйлдлийг теле камерыг ашиглан илрүүлж, тус гаалийн газарт албан утсаар тухай бүрт мэдэгдэж, гэмтлийг арилгуулах арга хэмжээг авагдсан.</p> <p>ГЕГ-ын ажлын байрны албан өрөөнөөс зөөврийн компьютер алдагдсан асуудлын хүрээнд Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэст тухайн цаг үеийн өдөр бүрийн бичлэгийг шүүн, бичлэгийг хуулбарлан хүргүүлж, уг асуудалтай холбогдлуулан албан хаагчдын нэвтрэх эрх бүхий картыг эрхийн хязгаарлалтын дагуу ГЕГ-ын барилгын албан өрөө бүрт шинээр таниулж тохиргоог хийлгүүлж, албан хаагчдын албан өрөөнд нэвтрэх эрхийн жагсаалтын ЗТГ-т хүргүүлсэн.</p>		
5.	Гаалийн байгууллагатай холбоотой	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1. Гаалийн лавлах 1800-1281 тусгай дугаарт 2023.01.02-	- Харьяа гаалийн газар, хороодод ашиглагдаж буй	2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Гаалийн байгууллага нийт 10427 дуудлага, гомдол мэдээлэл хүлээн авснаас Гаалийн лавлах 1800-1281	2024.01.02-2024.11.30	100%

<p>гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлүүлсэн байдал</p>		<p>ноос 2023.06.15-ны өдрийг дуустал нийт 2597 дуудлага бүртгэгдсэн байна. Үүнээс: -гомдол, шүүмжлэлтэй холбоотой-78 -Зөрчлийн мэдээлэл-8 Асуулт лавлагаан-2511 байсан. Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв"-өөр дамжуулан гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийт 141 гомдол, санал, хүсэлт хүлээн авсан (Гомдол - 120, Хүсэлт – 14, Санал – 6, Талархал-1).</p>	<p>санал, гомдол хүлээн авах дугааруудыг 1800-1281 тусгай дугаарт шилжүүлэн нэг цэгт төвлөрүүлж, сан үүсгэх нөхцөл бололцоог бүрдүүлсэн байна. - Гаалийн лавлах 1800-1281, Засгийн газрын гомдол мэдээлэл хүлээн авах 11-11 төвийн утсанд, Бүрдүүлэлтийн цахим нэгжид ирсэн гомдол мэдээллийг хүлээн авах, бүртгэх, холбогдох нэгжид шилжүүлэх, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулж, холбогдох нэгжийн болон ГЕГ-ын удирдлагад тайлагнасан байна. - Иргэд аж ахуйн нэгжид гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой</p>	<p>тусгай дугаарт гомдол-109, зөрчлийн мэдээлэл-12, санал-9, хүсэлт-8, шүүмжлэл-1, талархал-1, асуулт лавлагаа-8099 буюу нийт 8239 дуудлага, ЗГ Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан гаалийн байгууллагатай холбоотой гомдол-256, санал-22, хүсэлт-9, шүүмжлэл-0, талархал-2 буюу нийт 289 дуудлага, Цахим бүрдүүлэлтийн төвд цахимаар гомдол-259, хүсэлт-1640 тус тус бүртгэгдсэн байна.</p> <p>Гаалийн байгууллагад ирсэн гомдол, санал, хүсэлт, зөрчлийн мэдээллийн шийдвэрлэлтийн явцын 7 хоног бүрийн мэдээг Цахим болон шуурхай хуралд, ГЕГ-ын дарга болон ЗТГ-ын даргад тайлагнаж, удирдлагыг мэдээ мэдээллээр хангаж ажилласан.</p> <p>Иргэн, аж ахуйн нэгжид гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зөвлөгөө, мэдээлэл өгөх, гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн тайланг улирал бүр ОНХА-д, Гаалийн лавлах 1800-1281-ээр хүлээн авсан дуудлага, гомдол мэдээллийн сар бүрийн тайланг СДШХ-т тус тус хүргүүлэн ажилласан.</p> <p>"Гаалийн лавлах 1800-1281"-ын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор тусгай дугаарт ажиллах операторыг мэдээллээр хангах, цаашлаад мэдээлэл лавлагааны үйлчилгээг автоматжуулахад мэдээлэл лавлагааны нэгдсэн санг үүсгэх зорилгоор Хяналт бүрдүүлэлтийн газар болон Татвар орлогын газарт чиг үүрэгт хамааралтай тогтмол асуугддаг асуултуудын жагсаалтыг хүргүүлэн, хариултыг боловсруулан авч, кодчилон гарын авлага бэлтгэн ЗДАС-ын Дуудлагын төв цэсэд оруулан, 1800-1281-ийн үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн.</p> <p>Иргэн, аж ахуйн нэгжээс гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гаргасан санал, гомдлын шийдвэрлэлтийн тайланг улирал бүр Олон нийттэй харилцах нэгжид хүргүүлэн мөн Гаалийн</p>	
---	--	--	---	---	--

				<p>зөвлөгөө, мэдээлэл өгөх, гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг Олон нийттэй харилцах нэгжтэй хамтран олон нийтэд мэдээлэх ажлыг улиралд 1 удаа зохион байгуулсан байна.</p> <p>- Гаалийн лавлах 1800-1281 тусгай дугаарыг ОНХ нэгжтэй хамтран иргэн хуулийн этгээдэд сурталчилан таниулах ажлыг зохион байгуулсан байна.</p>	<p>байгууллагын цахим хуудас болох "www.customs.gov.mn-Мэдээ,мэдээлэл-Ил тод байдал-Өргөдөл, гомдол" хэсэгт 1,2,3,4-р улирлын мэдээг тус тус байршуулснаар ил тод нээлттэй байдлыг ханган мөн ЗУГ-т тус тус хүргүүлэн ажилласан.</p> <p>Харьяа гаалийн газар, хороодод ашиглагдаж буй санал, гомдол хүлээн авах дугааруудыг 1800-1281 тусгай дугаарт шилжүүлэн нэг шугамд төвлөрүүлж, Дуудлагын төвийн програмыг 1800-1281-ийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Ингэснээр:</p> <ul style="list-style-type: none"> - Иргэн, хуулийн этгээд Бүрдүүлэлтийн цахим төв, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Замын-Үүд дэх гаалийн газар болон Гаалийн зөвлөхийн аль нэгийг сонгон шууд холбогддог болсон. - Дуудлага шилжүүлэх боломжтой болсон (Дуудлага шилжүүлэх үед шилжүүлсэн дугаар дуудлагыг авч хариу өгсөн тохиолдолд оператор харилцуураа тавьдаг). - Хандсан дуудлага бүр автоматаар бүртгэгдэн, сан үүсэж байна. - Хүлээн авсан дуудлагын ярианы бичлэг 3 сараар хадгалагдаж, сан үүсэж байна. -Аваагүй, давхардаж ирсэн буюу алдагдсан дуудлагын бүртгэл автоматаар үүснэ. Иймд тухайн дугаарт эргэн холбогдож, дуудлага бүрийг алдахгүй ажиллах боломжтой болсон. 		
6.	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>2023 оны эхний 11 сарын байдлаар Хяналтын нэгдсэн төвд ЗДАС программын Үүрэг даалгаврын хэсэгт 9 үүрэг даалгавар өгөгдсөн ба биелэлтийг цаг нь хугацаанд нь</p>	<p>Удирдлагын шуурхай хуралдаан, Захиргааны зөвлөл болон Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан, Онлайн хурлаас өгсөн чиглэл, үүрэг даалгаврын</p>	<p>Тайлант хугацаанд ЗДАС программын Үүрэг даалгаврын хэсэгт нийт 11 үүрэг даалгавар өгөгдсөн ба биелэлтийг цаг хугацаанд нь оруулан ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан-1 - Ёс зүйн дэд хорооны хуралдаан- 1 - Зөвлөмж - 2 	2024.01.02-2024.11.30	100%

			<p>оруулан ажилласан. Үүнд: -Онлайн хурлын даалгавар-2 -Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан-1 -Зөвлөмж- 4 -Албан даалгавар 2 биелэлтийг хангаж, тайлагнаж ажиллалаа.</p>	<p>биелэлтийг хангаж ажилласан байна. Харьяа гаалийн газар хороодод өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулан, ЗДАСП-д үнэлж, дүгнэсэн байна.</p>	<p>- Үүрэг даалгавар - 6 биелэлтийг хангаж, тайлагнаж ажиллалаа. ХШҮДАГ-аас ирүүлсэн зөвлөмжийн хугацаа 2025.03.25-нд дуусах тул биелэлтийг оруулаагүй байна.</p> <p>ДГБ-ын "Жендэрийн эрх тэгш, ялгаатай байдал болон Ёс зүйн зааврын тэмдэглэл", "Байгууллагын Жендэрийн эрх тэгш, ялгаатай байдлыг үнэлэх" баримт бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор хамрагдах чиглэл, албан хаагчийн саналыг дэд хороонд бичгээр хүргүүлсэн.</p> <p>ГЕГ-ын даргын 2009 оны 169 дүгээр тушаалаар батлагдсан "Гаалийн лавлах 1281"-ийн үйл ажиллагааны зааврыг шинэчлэн боловсруулсан төсөлд Мэргэжлийн зөвлөлийн гишүүдээс гаргасан саналыг тусган батлуулах 06/01 дугаартай шийдвэрийн дагуу саналыг тусган, хэрэгжилтийг хангаж ажилласан.</p> <p>ХШҮДАГ-аас ирүүлсэн Гаалийн байгууллага систем даяараа ашигладаг мэдээллийн нэгдсэн баазтай болох, дүн шинжилгээний программуудыг өдөр тутмын ажилдаа нэвтрүүлж, ашиглаж сурах хэрэгцээ, шаардлагын талаарх зөвлөмжийн хэрэгжилтийг ханган, мөн цаашид хэрхэн ажиллах талаар нэгжийн гаргасан санал болон зөвлөмжийн биелэлтийг оруулсан.</p> <p>ГУБ, ГУАБ, удирдлага нэгжийнхээ үйл ажиллагаанд тогтмол мониторинг хийдэг, хоцрогдож буй ажил, арга хэмжээндээ анхаардаг, энэ тухай тайлагнаж хэвших гэсэн зөвлөмжийн дагуу нэгжийн нийт албан хаагчдын ажлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж (явцын мониторинг хийж), 7 хоног бүрийн ажлын тайланг гаргуулан, удаашралтай байгаа аливаа ажлын нөхцөл шалтгааныг хэлэлцэн, яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар нээлттэй санал солилцон ажиллаж байна.</p>		
--	--	--	---	--	---	--	--

					<p>ЗУГ-аас ирүүлсэн 4 үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган, биелэлтийг тухай бүрт нь оруулсан.</p> <p>СТ-өөс андуурч илгээсэн 1 үүрэг даалгаврыг СТ-өөс засвар буцаасан төлөвтэй байна. 2023 оны 11 дүгээр сард он дамнуулан ирүүлсэн 14 зөвлөмжийн биелэлтийг програмд тайлант хугацаанд харагдахгүй байгаагаас үүдэн оруулаагүй байна. Зөвлөмжийн биелэлтийг дотоод зурвасаар ЗУГ, ХШУДАГ-т хүргүүлсэн.</p> <p>Харьяа ГГХ-д 2 удаагийн үүрэг даалгаврыг хүргүүлж, биелэлтийг хамрах хугацаа болоогүй хэдий ч, биелэлт ирүүлсэн ГГХ-ыг дүгнэсэн.</p>		
7.	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	2023 оны нэгжийн үнэлгээ 4.5 байна.	<p>Албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг суурь түвшингээс бууруулахгүй байна.</p>	<p>Тайлант хугацаанд албан хаагч нар ажлын өдрийн өглөө орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлж, зайлшгүй шаардлагатай болон гадуур ажиллах тохиолдолд ЗДАС -д тухай бүр хүсэлтийг илгээж ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - томилолтоор ажилласан 19; - хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцсон 10; - ээлжийн амралттай 11; -ЗББНДБ-ын чөлөө-1; - Бусад -26; <p>-Хурлын өрөө 10 хүсэлтийг тус тус CERP-д тухай бүр оруулан, илгээж, хянуулсан.</p> <p>2024 оны эхний улиралд нэгжийн ГУАБ, ГУБ нар 59 илүү цаг ажилласан ба илүү цагаар ажилласан шалтгаан, тайлбарыг гаргаж, Захиргааны удирдлагын газарт 2024.04.22-ны өдрийн 51 тоот дотоод зурвасаар хүргүүлсэн.</p> <p>Албан хаагчдын ажлын цаг ашиглалтын байдалд тогтмол хяналт тавьж ажилласан ба ГУБ болон ГУАБ</p>	2024.01.02-2024.11.30	100%

					нарын ажлын үзүүлэлтэд цаг ашиглалтыг дүгнэж, ТЖАХ-ын ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд тусгаж дүгнэсэн.		
Зорилт 2. "ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДЭД БҮТЭЦ, ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ"							
1.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	2023 онд нэгжийн чиг үүрэгт хамааралтай бодлогын баримт бичиг тусгагдаагүй байна.	Бодлогын баримт, бичигт тусгагдсан нэгжийн чиг үүрэгт хамаарах арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж, тухай бүр тайлагнасан байна.	ШХТ-өөс 2024 онд дараах тайланг холбогдох нэгжүүдэд хүргүүлэн ажилласан. - Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн сар бүрийн болон 2024 оны эхний болон сүүлийн хагас жилийн тайланг Хуулийн хэлтсээр дамжуулан Сангийн яаманд; - Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний эхний болон сүүлийн хагас жилийн биелэлтийг ЗУГ-т; - Гаалийн ерөнхий газрын 2024 оны эхний болон сүүлийн хагас жилийн "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний биелэлтийн тайланг ЗУГ-т; - Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаанд холбогдох хуулийн хэрэгжилтийн эхний болон сүүлийн хагас жилийн биелэлтийг Хуулийн хэлтэст; - Авилгатай тэмцэх газраас Гаалийн ерөнхий газарт ирүүлсэн зөвлөмжийн тайланг ЗУГ-т; - Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлого, шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 02 дугаартай хуралдааны шийдвэрийн биелэлтийг хуулийн хэлтэст тус тус хүргүүлж биелэлтийг 100% ханган ажилласан. Алтанбулагийн чөлөөт бүсийг телехяналтын нэгдсэн системд холбох ажлын хүрээнд гаалийн байгууллагаас хамаарах ажлуудыг бүрэн хэрэгжүүлж ажилласан.	2024.01.02-2024.11.30	100%
2.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Нэгжийн чиг үүргийн дагуу Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд	Нэгжийн чиг үүрэгт хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын	ГЕГ-ын даргын 2009 оны 169 дүгээр тушаалаар батлагдсан "Гаалийн лавлах 1281-ийн үйл ажиллагааны заавар"-ыг шинэчлэн боловсруулж, ГЕГ-ын Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр холбогдох материал,	2024.01.02-2024.11.30	100%

			<p>гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлж, хэрэгжилтийг тайлагнаж ажилласан.</p> <p>Монгол улсын Ерөнхий сайдын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн №10 дугаартай албан даалгавар, Сангийн сайдын 2022_16 дугаартай "Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаар авах арга хэмжээний тухай" шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан.</p>	<p>хэрэгжилтийг ханган ажилласан байна.</p>	<p>танилцуулгыг хүргүүлэн, 2024 оны 06-р сарын 14-ний 06/01 хуралдаанаар хэлэлцүүлж, ГЕГ-ын даргын А/394 дүгээр тушаалаар батлуулсан.</p> <ul style="list-style-type: none"> - Зааврын төслийг нэгжийн хэмжээнд 2024 оны 02 дугаар сард 2 удаа, 04 дугаар сард 2 удаа, 05 дугаар сард 1 нийтдээ 5 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан; - Шинэчлэн найруулсан төсөлтэй холбоотойгоор ГЕГ-ын ЗББНДБ-аас ирүүлсэн саналыг нэгтгэж, төвөөрөө саналыг нэг бүрчлэн хэлэлцэж, тусган шийдвэрлэсэн; - Журам, зааврын шинэчилсэн найруулгын төслийг 2024 оны 01, 03, 05 дугаар сард нийтдээ 3 удаа Дотоод зурвасаар Хуулийн хэлтэст хүргүүлж, хянуулсан; - Журам, зааврын шинэчилсэн найруулгын төслийг Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж, холбогдох танилцуулга (Word, Powerpoint)-ыг бэлтгэж, Захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн. <p>Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд КАИС системд ирүүлсэн гаалийн мэдүүлэгт батлагдсан шалгуур үзүүлэлтүүдээр өндөр эрсдэлтэй гэж сонгогдсон гаалийн мэдүүлэгт телекамерын системийг ашиглан давхар хяналт тавьж ажилласнаар нийт 112 мэдүүлэгт дүн шинжилгээ хийн, зөвлөмж илгээснээс хяналт шалгалтаар гаалийн үнэ, барааны нэр төрөл, тоо хэмжээ, ангилал худал мэдүүлж, татвараас зайлсхийхийг завдсан нийт 87 зөрчил илрүүлсэн. Илрүүлсэн зөрчлийг авч үзвэл Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 11.21-ийн 1.1, 1.2, 12 заалтуудын дагуу арга хэмжээ авагдсан байна.</p> <p>Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд эхний хагас жилийн байдлаар гаалийн байгууллагад нийт 10427 дуудлага хүлээн авснаас 414 гомдол, санал, хүсэлтийг бүртгэн авч, холбогдох нэгж рүү шуурхай шилжүүлэн, хуулийн</p>		
--	--	--	--	---	--	--	--

					хугацаанд шийдвэрлүүлэн, гомдол гаргагч иргэн, хуулийн этгээдэд эргэн мэдэгдэж ажилласан байна. Дээрх хуулийн хэрэгжилтийн , тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2024 оны эхний болон хагас жилийн тайлан, ЗГ- хуралдааны 02 шийдвэрийн биелэлтийг тус тус Хуулийн хэлтэст хүргүүлсэн.		
3.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	2023 онд энэ ажил төлөвлөгдөөгүй болно.	Нэгжийн эрсдэлийг таньж тогтоон үүсгэнэ. сан	Тус нэгжийн албан хаагч нар 3 удаагийн хурал хийж, ЭУХ болон ХШҮДАГ-ийн хамтарсан 2 удаагийн сургалтад хамрагдсан. ГЕГ-ын даргын 2022.12.14-ны өдрийн А/342 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх" журмын 5.7.2-5.7.4 дэх хэсэгт заасны дагуу эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийн давтамж, үр дагаварын үржвэрээр эрсдэлийн матрицаа гаргаж, эрсдэлийн түвшинг тодорхойлсон. /файл хавсаргав/ Эрсдэлийн түвшинг тус журмын 5.8-д заасан итгэлцүүрийн үржвэрээр үржүүлж эрсдэлийн нийт үнэлгээг гаргаж, эрсдэлийн түвшингээр эрэмбэлэн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө гарган ажилласан. Эхний хагас жилд 8, сүүлийн хагас жилд 12 эрсдэлийг тооцож, таньж тогтоон, үнэлэн эрсдэлийн санг баяжуулж ажилласан. Дээрх 20 эрсдэлээс ажил таслалт, хоцролтыг хянахтай холбоотой, техник тоног төхөөрөмжтэй холбоотой, шинэ технологи нэвтрэхтэй холбоотой, хүний нөөцийн чадамжтай холбоотой, програм хангамж болон техник хангамжтай холбоотой эрсдэлүүдийн нийт үнэлгээ тус тус 5-аас дээш өндөр эрсдэлтэй байсан ба эдгээр эрсдэлийг бууруулах арга хэмжээг бүрэн авч хэрэгжүүлснээр Шуурхай хяналтын төвийн дотоод эрсдэлийн санд бүртгэгдсэн өндөр түвшний эрсдэлүүдийг 5-аас дотогш бууруулж, 100%-ийн үр дүнтэй ажилласан байна.	2024.01.02-2024.11.30	100%
4.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй ажил	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн ГЕГ-ын даргын А/248 тоот тушаалаар "Хяналтын нэгдсэн	Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тухай бүр орж	Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, ажлын хэсгийн хэрэгжилтийг хангах чиглэлээр: ГЕГ-ын даргын 2009 оны 169 дүгээр тушаалаар батлагдсан "Гаалийн лавлах 1281-ийн үйл ажиллагааны заавар"-ыг шинэчлэн боловсруулж,	2024.01.02-2024.11.30	100%

			<p>төвийн үйл ажиллагааны заавар"-ыг хавсралт ёсоор батлуулсан. Тушаалыг ЗДАС программд байршуулан, тушаалтай танилцаж, хэрэгжүүлж ажиллахыг ГЕГ-ын ЗББНДБ болон харьяа гаалийн газар хороодод Спаркаар мэдэгдэж ажилласан.</p>	<p>ажилласан байна. 2009 оны 169 дүгээр тушаалаар батлагдсан "Гаалийн лавлах 1281"-ийн үйл ажиллагааны зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулсан байна.</p>	<p>2024 оны 01, 03, 05 дугаар сард нийтдээ 3 удаа Дотоод зурвасаар Хуулийн хэлтэст хүргүүлж, ГЕГ-ын Мэргэжлийн зөвлөлийн 2024 оны 06-р сарын 14-ний 06/01 хуралдаанаар хэлэлцүүлж, ГЕГ-ын даргын А/394 тушаалаар батлуулсан.</p> <p>МУЗГ-с хэрэгжүүлж буй "Гаалийн шинэчлэл"-ийн хүрээнд Боршоо, Сүхбаатар, Алтанбулаг боомтод телехяналтын систем нийлүүлэх 2023 оны Б-15 дугаар гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, туршиж шалгах, хүлээн авах ажлын хэсэг, Бүрдүүлэлтийн цахим төвийн камержуулалтын тендерийн үнэлгээний хороо, ЗҮ боомтод телехяналтын тоног төхөөрөмж нийлүүлэх С20240102033 гэрээний хэрэгжилтийн хангах, Гаалийн хяналт шалгалтын "УХААЛАГ ГАРЦ" иж бүрдэл бүхий тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах гэрээний хэрэгжилтийг хангах ГЕГ-ын даргын 2024 оны А/191 тушаалаар батлагдсан ажлын хэсэгт нэгжийн албан хаагчид орж ажилласан. Ажилласан үр дүн тайланг файлаар хавсаргав. Цаг үеийн шинжтэй 5 төлөвлөгөөт арга хэмжээнд тусгагдсан ажлын биелэлтийг цаг тухайд нь холбогдох нэгжид хүргүүлсэн. ДГБ-аас Онилгооны төвийн судалгаанд хамрагдаж, төвийн мэдээллийг бэлтгэж хүргүүлсэн. Нийт 10 удаагийн томилолтоор ажиллаж, үүнээс Ухаалаг гарцтай холбоотойгоор 6 удаагийн томилолтоор ажилласан. Гаалийн лавлах болон Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн санал, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийн, кодчилсон гарын авлагыг боловсруулан, Гаалийн лавлах 1800-1281 тусгай дугаарын өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн /ЗДАС дуудлагын төв цэс харах боломтой/.</p> <p>КОИСА төслийн дэд дарга И Кан Соноор удирдуулсан төслийн багийн гишүүдтэй уулзалт зохион байгуулж кайс програмын эрсдлийн удирдлага, ачаа тээшний удирдлагын хэсэг, их өгөгдөлд суурилсан онилгооны дэд програмын</p>		
--	--	--	---	--	---	--	--

					<p>хөгжүүлэлтэд хиймэл оюун ухаан ашиглах, рэнтгэн зургийн датаг хяналт шалгалтад ашиглах боломжийн талаар тодорхой саналууд хүргүүлсэн.</p> <p>Албаны дотоод фэйсбүүк групп дээр харьяа газар хороод хэрхэн ЗДАС програмд өөрт ирсэн гомдол мэдээллийг бүртгэх, шийдвэрлэлт оруулах, хянах талаарх 2 минутийн видео бичлэг оруулж танилцуулга хийсэн.</p>		
5.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй ажил	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	2023 онд энэ ажил төлөвлөгдөөгүй болно.	<p>Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Гаалийн лавлах 1800-1281, ЗГ 11-11, Цахим бүрдүүлэлтийн төвд иргэд, олон нийтээс "Гаалийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эхний болон сүүлийн хагас жилийн дүн шинжилгээ, тайланг ЗУГ-т 2 удаа хүргүүлэн ажилласан.</p> <p>- Хилийн 24 боомт, харьяа гаалийн 19 газар хороодын гаалийн хяналтын бүсүүдийг Шуурхай хяналтын төвийн телехяналтын нэгдсэн системд бүрэн холбож, телехяналтыг хэрэгжүүлэн ил тод байдлыг ханган ажиллаж байгаа талаар, мөн Гаалийн лавлах 1800-1281 тусгай дугаарын зөвлөх үйлчилгээг иргэд олон нийтэд сурталчлан таниулах, гаалийн байгууллаас үзүүлж байгаа үйлчилгээнд хүнд суртал, албан хаагчийн ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээлэл, санал хүсэлтийг ирүүлэн хамтран ажиллаж, оролцоотой байх талаарх мэдээллийг тус тус бэлтгэн, АТГ-тай хамтран хийсэн 3 мин шторк-д мэдээллийг тусгуулсан. Тус шторк АТГ-ын цахим хуудаст байршуулагдсан.</p> <p>- Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн эхний болон сүүлийн хагас жилийн тайланг ЗУГ-т хүргүүлсэн.</p> <p>- "Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг</p>	2024.01.02-2024.11.30	100%	

					сурталчлах хөтөлбөрийн биелэлтийг ОНХА-д хүргүүлсэн. -Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажилаагааны төлөвлөгөөний биелэлтийг эрчимжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан "гаалийн лавлах 1800-1281"-г олон нийтэд суртачлах наалт бүхий эх загварыг боловсруулж, загварыг батлуулж, биелэлтийг хангасан.		
--	--	--	--	--	---	--	--


Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	ГЕГ, Дотоодын цэргийн штабаас хамтран 2023.05.11-12-ны өдрүүдэд зохион байгуулсан "Шуурхай удирдлага, зохицуулалтын дадлага, сургалт", Удирдлагын академи, Төрийн албаны сургуулийн "Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт" /2023-06-09. №А3831/,	Хууль эрх зүйн мэдлэг, мэдээллээ бататгаж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	<ul style="list-style-type: none"> Сангийн яамнаас зохион байгуулсан Жендэрийн стратегийн үнэлгээ-ний талаарх техникийн зөвшилцөх сургалт- семинарт оролцсон. Сургалтын төвөөс зохион байгуулсан VR 4 цагийн сургалтад 2024 оны 01-р сард хамрагдсан. Anti-Money laundering investigation techniques workshop-д 2024 онд хамрагдсан. Төрийн албаны удирдах албан тушаалтны ур чадварыг хөгжүүлэх нь сэдэвт сургалтад хамрагдаж, сертификат авсан. 	2024.01.02-2024.11.30	100%

			2023.08.02-08-ны өдрүүдэд Хонгонг улсад AXIS компаниас зохион байгуулсан "Орчин үеийн телехяналтын камерыг гаалийн хяналт шалгалтын зорилгоор ашиглах нь" сэдэвт сургалтад тус тус амжилттай хамрагдсан.				
2	Англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Англи хэл бие даан сурч, хэлний зохих түвшний мэдлэгтэй болсон.	Англи хэлний мэдлэгийн түвшинг дээшлүүлсэн байна.	Wall street english 1 жилийн сургалтанд хамрагдан, англи хэлний түвшинг дээшлүүлсэн.	2024.01.02-2024.11.30	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Шуурхай хяналтын төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

 /Ц. Хатанболд/

2024 оны 12 сарын 10 өдөр

1112

ШУУРХАЙ ХЯНАЛТЫН ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.ХАТАНБОЛДЫН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ
ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Шуурхай хяналтын төв

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт оноо (70 оноо)
1	2	3	4
1	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		63,21

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийг хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах		14
2.	Англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх		14
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо:			14

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	12
2.	Удирдан зохион байгуулах	10
3.	Асуудал шийдвэрлэх	12
4.	Манлайлах	10
5.	Багаар ажиллах	10
6.	Харилцаа	14
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7.	Мэргэжлийн ур чадвар 1.	-
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		11,33

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
-----	---------------------	--------------------------


1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт	63,21
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	14
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ	11,33
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт	-
Нийт оноо= (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		88,5

Үнэлгээ өгсөн:

Гаалийн ерөнхий газрын дарга

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Шуурхай хяналтын төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



Төсвийн шууд захирагч:

(Р.Отгонжаргал)

2024.12.19 (огноо)

Нэгжийн дарга:

(Ц.Хатанболд)

2024.12.20 (огноо)